

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.5 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 190.5.5, 190.5.6 дахь заалт нэмсүгэй :

“190.5.5.Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх эмнэлгийн байгууллага нь харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтантай байна.

190.5.6.Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ авагдсан этгээдийг арга хэмжээнээс чөлөөлөхөд асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл садангийн хүнгүй, хүлээн авахаас татгалзсан тохиолдолд Шүүх хэвтэн эмчлүүлж буй эмнэлгийн байгууллагын энгийн тасагт шилжүүлж болно.”

**2 дугаар зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурданаар өөрчлөн найруулсугай:

#### **1/190 дүгээр зүйлийн 190.3 дахь хэсэг:**

“190.3.Энэ хуулийн 190.1-д заасан этгээдийн эмчилгээний зардал, 190.2-д заасан эмчлэх байгууллагад хүргэх зардлыг тус тус улсын төсвөөс санхүүжүүлнэ.”

#### **2/93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэг:**

“93.4.Төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүйтохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч,хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах тухай нэхэмжлэлийг шүүх хангасан бол энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж төлбөрийг барагдуулна.”

**3 дугаар зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 190.9, 190.10 дахь хэсгийн “Эмнэлгийн чанартай албадлагын” гэснийг “Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх” гэж, мөн зүйлийн 190.4, 190.5, 190.6, 190.7, 190.8 дахь хэсгийн “эмнэлгийн чанартай албадлагын” гэснийг “сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1.4 дэх заалт, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг